



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2019 / 3



## АГУУЛГА



Хөдөлмөр



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Гэмт хэрэг



Цахилгаан холбоо

## **Аргачлалын тайлбар**

### **Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### **Мөнгө, банк**

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно. Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно. Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

### **Үнэ**


Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний

үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.



$I_{ct}^L$  -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

$t$  –тайлант үе,  $0$  – суурь үе,

$P_{it}$  -'i' барааны тайлант үеийн үнэ,

$P_{i0}$  -'i' барааны суурь үеийн үнэ,

$Q_{i0}$  -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\square$  -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

### Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал

түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

### Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

## **Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

## **Хөдөлмөр**

Эдийн засгийн идэвхитэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2019 оны 03 дугаар сарын байдал)

### Бүртгэлтэй ажилгүй иргэн


Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 3 дугаар сарын байдлаар 811 байгаагийн 48.7 хувь нь буюу 395 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 4 хүнээр буюу 0.5 хувиар өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнөөр нь авч үзвэл 217 нь дээд, 26 нь тусгай дунд, 88 нь техник мэргэжлийн, 402 нь бүрэн дунд, 48 нь суурь, 17 нь бага, 13 нь ямар ч боловсролгүй байна хүмүүс байна.


**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2019 оны 3 сарын эцэст**



**Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэд**



**Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2019 оны эхний 3 сарын байдлаар**




### Нийгмийн халамж

Нийгмийн даатгалын шимтгэлээр 3 тэрбум 320.7 сая төгрөг, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн санхүүжилтээр 5 тэрбум 310.0 сая төгрөг, бүгд 8 тэрбум 630.7 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, нийт 7802 хүнд 7 тэрбум 422.4 сая төгрөг тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 414 даатгуулагчид 315.1 сая, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 26.1 сая, ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлсэн 50 иргэнд 67.5 сая төгрөгийн зардлыг тус тус бүрэн олгожээ.

## Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд 2019 оны 3 сарын байдлаар 326 эх амаржиж 330 хүүхэд мэнд төрлөө. Нялхсын эндэгдлийн 13 тохиолдол, 1-5 хүртэлх хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгджээ.



Цочмог халдварт өвчин 111 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 33.7 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчний 39.6 хувийг салхинцэцэг, 8.1 хувийг гар хөл амны өвчин, 40.5 хувийг БЗХӨ, 11.8 хувийг бусад халдварт өвчин эзлэж байна.



### Халдварт өвчний төрлөөр 2019 оны 3 сарын байдлаар




## Гэмт хэрэг

Аймгийн цагдаагийн газраас ирсэн мэдээгээр нийт байгууллага, иргэдийн 159.5 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 95 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс хулгай гэмт хэрэг 23 буюу (24.2%), залилах гэмт хэрэг 20 буюу (21.0%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 25 буюу (26.3%), бусад хэрэг 27 (28.5%) тус тус эзэлж байна.


Нийт 3632 зөрчил бүртгэгдэж 3550 хүн, хуулийн этгээд 45.5 сая төгрөгийн торгууль төлсөн байна. Гэмт хэрэгт эмэгтэй 7, хүүхэд 5 холбогдож, гэмт хэргийн улмаас нас барсан 3 хүн, гэмтсэн 23 хүн, баривчлагдсан 27 хүн, саатуулагдсан 109 хүн, тээвэрийн хэрэгсэл жолоодох эрх хасуулсан 43 хүн бүртгэгджээ.

Гарсан нийт хэргийн 50.5 хувь нь Алтай хот буюу Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.


Гэмт хэргийн хэлбэр тоогоор 2019 оны 3 сард



Гэмт хэргийн төрөл хувиар 2019 оны 3 сард



Гарсан гэмт хэргийн тоо, учирсан хохирол сая төгрөгөөр, жил бүрийн нэгдүгээр улирлаар



## Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2019 оны 3 дугаар сарын эцэст 95.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 20.2 тэрбум төгрөг буюу 26.9 хувиар өсчээ.

Үзүүлэлт	Хугацаа	
	2018-III	2019-III
<b>Мөнгөний нийлүүлэлт M2</b>	<b>74943.3</b>	<b>95111.5</b>
Сарын өөрчлөлт, хувиар	15.2	26.9
<b>Нийт хадгаламж</b>	<b>65372.0</b>	<b>83626.7</b>
Сарын өөрчлөлт, хувиар	14.3	27.9
<b>Төгрөгийн хадгаламж</b>	<b>65232.8</b>	<b>83253.8</b>
Сарын өөрчлөлт, хувиар	14.6	27.6
<b>Валютын хадгаламж</b>	<b>139.2</b>	<b>373.0</b>
Сарын өөрчлөлт, хувиар	-45.6	168.0

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 0.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 0.2 тэрбум төгрөг буюу 53.3 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар сарын эцэст 123.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 21.6 тэрбум төгрөг буюу 21.1 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар сарын эцэст 966.7 сая төгрөг болж, өмнөх оноос 266.9 сая төгрөг буюу 38.0 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.8 хувийг эзэлж байна.


Чанаргүй зээл 2019 оны 3 дугаар сарын эцэст 916.2 сая төгрөг болж өмнөх оноос 263.0 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

## Төсвийн орлого

Аймгийн төсөвт нийт 2.2 тэрбум төгрөг хүрч, төлөвлөгөөг 117.8 хувиар, үүнээс татварын орлого 1.7 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөг 102.4 хувиар биелүүлсэн байна.


Татварын бус орлого 317.2 сая төгрөг төлөвлөгөөг 286.8 хувиар, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 238.1 сая төгрөг болж төлөвлөгөөг 133.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

### Орлогын бүтэц, мянган төгрөгөөр 2019 оны III сард



Аймгийн төсвийн бүрдэл нь татварын орлогоор 84 хувь, татварын бус орлогоор 16 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна.


### Төсвийн орлогын төрөл, мянган төгрөгөөр 2019 оны III сард



### Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 69.2 хувийг санхүүжүүлэв. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардлын 74.4, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 93.0, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 93.1, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 85.1, хангамж, бараа материалын зардлын 69.7, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 21.9, эд хогшил, урсгал засварын зардлын 58.8, томилолт, зочны зардлын 42.1, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын 44.5, бараа үйлчилгээний бусад зардлын 75.7, урсгал шилжүүлэгийн 156.9 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд 2.5 сая төгрөгийн авлагатай, 319.5 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.



### Үнэ


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2018 оны 3 дугаар сард өмнөх сараасаа 0.8 хувиар, өмнөх оны жилийн эцсээс 3.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 4.5 хувь, суурь үеийнхээс 9.1 хувиар өссөн байна. Ерөнхий индекс 2018 оны 3 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс 4.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2018-03	2018-03	2018-03	2018-03
		2015-12	2017-03	2017-12	2018-02
<b>Ерөнхий индекс</b>	<b>100</b>	<b>109.1</b>	<b>104.5</b>	<b>103.1</b>	<b>100.8</b>
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	105.2	109.6	109.9	104.0
Согтууруулах ундаа, тамхи	3.2	114.1	111.0	109.4	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	110.9	102.4	100.6	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	111.3	102.8	102.0	98.3
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	113.1	104.7	100.7	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	106.2	104.4	100.0	100.0
Тээвэр	12.2	106.8	107.4	103.9	100.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	97.6	98.8	98.8	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	101.6	100.2	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	126.4	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	110.4	108.1	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.7	101.1	100.0	100.0

## Хөдөө аж ахуй


Аймгийн хэмжээнд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар төллөх насны 1570.8 мянган хээлтэгч малын 327 мянга буюу 20.8 хувь нь эхний 3 сард төллөсөн байна. Эм ямааны 18.5 хувь, эм хонины 28.3 хувь, ингэний 12 хувь, үнээний 5.2 хувь, гүүний 1.7 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 97.3 хувь буюу 319.5 мянган төл бойжиж байна. Том малын зүй бусын хорогдол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар аймгийн хэмжээнд 25779 толгой болж, өмнөх оны мөн үеийхээс 67.5 мянга буюу 3.6 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 943, үхэр 1119, тэмээ 31, хонь 7383, ямаа 16303 байна. Нийт хорогдлын 26.6 хувийг хонь, 63.2 хувийг ямаа эзэлж байна.



### Хорогдсон төл, 2019 оны 1-р улирлын байдлаар, сумаар



### Хорогдсон том мал, 2019 оны 1-р улирлын байдлаар



## Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2019 оны 3 дугаар сард аймгийн төв болох Есөнбулаг суманд үхрийн шир 12.0 мян.төг, адууны шир 10.0 мян.төг, хонины арьс 1.5 мян.төг, ямааны арьс 42.0 мян.төг байна.

## Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний 3 дугаар сард 3 тэрбум төгрөгт хүрчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 79.2 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл, 6.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 14.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 3.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.


Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 2019 оны 3 сарыг байдлаар, хувиар




## Холбооны газар

Суурин телефон цэгийн тоо 526, холбооны газрын орлого 41.1 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 28.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого сая төг



Суурин утасны цэгийн тоо



## 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

**Говь-Алтайн нутаг.** Энэ сарын агаарын дундаж температур нь Говь-Алтайн өмнөд хэсгээр 7-11 градус, бусад нутгаар 1-6 градус дулаан буюу дунджийн орчим байх төлөвтэй.




Нэгдүгээр арав хоногийн эхний хагас, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр бага зэрэг хүйтэрч Алтайн өвөр говиор шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 10-15 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр харьцангуй дулаарч Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 10-15 градус дулаан, Алтайн өвөр говиор шөнөдөө 4-9 градус, өдөртөө 20-25 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 14-19 градус дулаан байна.

Бусад хугацаанд Алтайн өвөр говиор шөнөдөө 1-6 градус, өдөртөө 14-19 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан байна.

Энэ сард Говь-Алтайн ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.



Нэгдүгээр арав хоногийн эхэн болон эцсээр нутгийн нутгийн өмнөд хэсгээр, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд, хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим газраар 14-16м/с, Алтайн уулархаг нутгаар зарим үед 20-24 м/с хүрч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.



# Хөдөлмөр

**ХӨДӨЛМӨР  
LABOUR**

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст  
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшинээр	By educational level	2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	3-сар In march	
						2018	2019
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>1044</b>	<b>786</b>	<b>796</b>	<b>919</b>	<b>807</b>	<b>811</b>
Үүнээс: эмэгтэй	of which:female	547	435	430	462	465	395
Дээд боловсролтой	Higher education	252	265	280	226	272	217
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	72	35	49	46	29	26
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	81	70	66	72	93	88
Бүрэн дунд	Upper secondary school	483	341	331	475	350	402
Суурь	Compulsory secondary school	112	42	41	59	40	48
Бага	Primary school	35	28	27	23	21	17
Боловсролгүй	Uneducated persons	9	5	2	18	2	13

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2019 оны 3 сарын эцэст  
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of march 2019**

Үүнээс: насны бүлгээр of which:by age group

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	15-24	25-34	35-44	45-59	55-59	60+						
			Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female						
I														
II	879	430	183	93	290	145	230	119	147	63	20	6	9	4
III	811	395	184	98	267	126	197	103	135	59	21	7	7	2

**2019 ОНЫ 3 САРД АЖИЛГҮЙЧҮҮДЭЭС ТАЙЛАНТ САРД АЖИЛД ОРСОН ХҮН**  
**NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 2 months of 2019**

Сар Month	Бүгд Total	Төрийн өмчит үйлдвэрийн газарт	Төрийн төсөвт байгууллагад Government organization	Компани Company	Хоршоо Cooperative	Бусад Other
I						
II	7		5			2
III	40		29	2		9

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР**  
**NUMBER OF UNEMPLOYED, by som**

ᠨᠣᠶ	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	3-р сар		
						march		
						2018	2019	2019%
Есөнбулаг	Yesunbulag	284	326	353	487	445	399	89.7
Алтай	Altai	40	10	27	17	18	12	66.7
Баян-Уул	Bayan-Uul	22	40	28	30	35	21	60.0
Бигэр	Biger	56	35	24	29	32	23	71.9
Бугат	Bugat	26	19	31	30	28	28	100.0
Дарив	Darib	47	17	12	54	14	58	414.3
Дэлгэр	Delger	45	44	75	24	22	20	90.9
Жаргалан	Jargalan	33	11	6	11	6	8	133.3
Тайшир	Taishir	17	15	16	3	17	5	29.4
Тонхил	Tonhil	68	20	11	30	12	26	216.7
Төгрөг	Tugrug	37	21	16	21	14	21	150.0
Халиун	Haliun	35	25	30	25	18	17	94.4
Хөхморьт	Huhmorit	15	34	16	12	12	9	75.0
Цогт	Tsogt	73	61	63	38	38	37	97.4
Цээл	Tseel	37	15	16	33	33	51	154.5
Чандмана	Chandmana	75	34	45	42	53	46	86.8
Шарга	Sharga	46	34	12	18	15	15	100.0
Эрдэнэ	Erdene	25	25	15	15	17	15	88.2
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	63	-	-		-		
<b>ДҮН</b>	<b>TOTAL</b>	<b>1044</b>	<b>786</b>	<b>796</b>	<b>919</b>	<b>829</b>	<b>811</b>	<b>97.8</b>



# **Нийгмийн даатгал, халамж**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан, даатгалын төрлөөр

REVENUE OF SOCIAL INSURANCE FUND AND INSURERS, by types of funds and insurance

Үзүүлэлт	Indicators	Сая төгрөг / Mln tugrug	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид / Pensionaries, who got pension from the social insurance fund
Нийгмийн даатгалын сангийн орлого	Revenue of social insurance fund	<b>9436.77</b>	<b>8289</b>
Тэтгэврийн даатгалын сангийн	Retirement insurance fund	7964.94	7802
Тэтгэмжийн даатгалын сангийн	Benefit insurance fund	402.66	414
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Health insurance fund	790.82	0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	IAOD insurance fund	211.39	23
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Unemployment insurance fund	66.96	50
Нийгмийн даатгалд даатгуулагчид / The number of insurers			
Заавал даатгуулагчид / Compulsory insurers			7791
Сайн дураар даатгуулагчид / Voluntary insurers			2461
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид / Health insurance insurers			31905

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО ЗАРЛАГА, халамжийн төрлөөр

REVENUE AND EXPENDITURE OF SOCIAL WELFARE SERVICES, by types of welfare

Үзүүлэлт	Indicators	Орлого сая.төг / Revenue	Зарлага сая.төг / Expenditure	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авсан иргэд / Beneficiaries of social welfare pensions, allowances, benefits and concession
Бүгд	Total	<b>2,709.20</b>	<b>2,528.50</b>	<b>23,376.00</b>
Нийгмийн халамжийн үйлчилгээ	Social welfare services	1137.1	1080.5	8318
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	Allowance to pregnant and lactating mothers	60.8	59.6	681
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	Benefits for honored elders	20.7	14	28
Алдарт эхийн одонгийн тусламж	Allowances for elders with "The medal of glorious mother"	676.2	648	4866
Хүнс, тэжээлийн хөнгөлөлт	Benefits of food	153.8	117.8	4431
Насны хишиг	Age grace	195.0	186.1	2195
Цалинтай ээж		397.3	386.0	2742
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж		38.3	36.5	115
ОНОТХҮЙлчилгээ	Other welfare services	30.0	0	0

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан, даатгалын төрлөөр			
<i>REVENUE OF SOCIAL INSURANCE FUND AND INSURERS, by types of funds and insurance</i>			
Үзүүлэлт	Indicators	Сая төгрөг / Mln tugrug	Нийгмийн даатгалын тэтгэвэр авагч / who got pension insurance fund
Нийгмийн даатгалын сангийн орлого	Revenue of social insurance fund	<b>9436.77</b>	<b>8289</b>
Тэтгэврийн даатгалын сангийн	Retirement insurance fund	7964.94	7802
Тэтгэмжийн даатгалын сангийн	Benefit insurance fund	402.66	414
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Health insurance fund	790.82	0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	IAOD insurance fund	211.39	23
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Unemployment insurance fund	66.96	50
Нийгмийн даатгалд даатгуулагчид / The number of insurers			
Заавал даатгуулагчид / Compulsory insurers			7791
Сайн дураар даатгуулагчид / Voluntary insurers			2461
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид / Health insurance insurers			31905



**Эрүүл мэнд**

**ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**  
**PUBLIC HEALTH OF POPULATION**

№	Сумын нэр	Soum	Төрсөн эх Women who gave births		Эхийн эндэгдэл Maternal Deaths		Төрсөн хүүхэд Births		Нялхасын эндэгдэл Infant mortality		1-5 хүртэлх настай хүүхдийн эндэгдэл Under-five mortality		Нийт нас баралт Deaths		Эмнэлэгт нас баралт Deaths	
			2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
1	Есөнбулаг	Yesunbulag	249	298			255	302	6	9		1	27	32	8	13
2	Алтай	Altai	2	4			2	4	0	0		1	1	2	1	0
3	Баян-Уул	Bayan-Uul	2				2		0	0		0	7	7	1	
3	Бигэр	Biger	2	3			2	3	0	0		0	1	1		
4	Бугат	Bugat	1	1			1	1	0	0		0		8		1
5	Гуулин	Gulin							0	0		0	2	0		
5	Дарив	Darib	2	3			1	3	0	1		0	3	1	2	
6	Дэлгэр	Delger	2	1			2	1	0	0		0	5	0		
7	Жаргалан	Jargalan							1	0		0	2	0	1	
8	Тайшир	Taishir							1	0		0	2	3		
8	Тонхил	Tonhil	4	2			4	2	0	0	1	0	6	1	1	
9	Төгрөг	Tugrug	3				3		0	2		0		4		4
10	Халиун	Haliun	1	1			1	1	0	0		0	7	2	1	
10	Хөхморьт	Huhmorit		2				3	0	1		0	5	6	2	4
11	Цогт	Tsogt		3				3	0	0	1	0	5	4	2	1
12	Цээл	Tseel	3	1			3	1	0	0		0	2			
12	Чандмана	Chandmani	4	4			4	4	0	0		0	2	3		
13	Шарга	Sharga							0	0		0	1	1		
14	Эрдэнэ	Erdene	4	3			4	2		0		0	1	4		
15	Баянтоорой	Bayantoroi							0	0		0	5	2	1	1
<b>22</b>	<b>Дүн</b>	<b>Total</b>	<b>279</b>	<b>326</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>284</b>	<b>330</b>	<b>8</b>	<b>13</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>84</b>	<b>81</b>	<b>20</b>	<b>24</b>

№	Сумын нэр	Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд Infectious Diseases		Үүнээс: Of which: БЗХӨ STID													
			2018	2019	Трихоминаз Trichomoniasis		Тэмбүү Syphilis		Заг хүйтэн Гонорреа Gonorrhoea		Гепатит Hepatite		Сүрьеэ Tuberculosis		Улаан бурхан		Бусад Other	
					2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
1	Есөнбулаг	Yesunbulag	52	64	3	1	8	10	2	14			1	2			38	37
2	Алтай	Altai	1	1			1			1							0	0
3	Баян-Уул	Bayan-Uul	0	10													0	10
3	Бигэр	Biger	3	0			2										1	0
4	Бугат	Bugat	7	8			7										0	8
5	Гуулин	Gulin	0	1									1				0	0
5	Дарив	Darib	1	0	1		0										0	0
6	Дэлгэр	Delger	1	2				1		1	1						0	0
7	Жаргалан	Jargalan	0	3			0	2		1							0	0
8	Тайшир	Taishir	2	1				1									2	0
8	Тонхил	Tonhil	2	1										1			2	0
9	Төгрөг	Tugrug	4	0			3										1	0
10	Халиун	Haliun	1	2			1	2									0	0
10	Хөхморьт	Huhmorit	1	3			0	1		1			1				0	1
11	Цогт	Tsogt	0	2				1		1							0	0
12	Цээл	Tseel	0	1			0	1									0	0
12	Чандмана	Chandmani	1	0			0										1	0
13	Шарга	Sharga	1	2			1	1									0	1
14	Эрдэнэ	Erdene	0	6						1							0	5
15	Баянтоорой	Bayantoroi	0	0													0	0
16	Харьяаллын бус		6	4	3		1	4	2								0	0
22	Дүн	Total	83	111	7	1	24	24	4	20	1	1	2	3	0	0	45	62



**Гэмт хэрэг, гал**

**БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, хэргийн төрлөөр, жил бүрийн эхний 3 сарын байдлаар**  
**NUMBER OF COMMITTED OFFENCES, by classification and types of crimes,**  
**in the first 3 months of selected years**

Үзүүлэлт		Өссөн дүнгээр				
		№	2018 III	2019 III*	Харьцуулалт	
					тоо	Хувь
<b>Нийт гэмт хэрэг</b>		<b>1</b>	<b>46</b>	<b>95</b>	<b>49</b>	<b>206.5</b>
үүнээс	Хөнгөн	2	36	77	41	213.9
	Хүнд	3	10	18	8	180.0
	Хүний амьд явах эрхийн эсрэг	4	5	5	0	100.0
	үүнээс Хүнийг алах	5	1	0	-1	0.0
	үүнээс Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	6	0	1	1	0.0
	үүнээс Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	7	3	4	1	133.3
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8	14	25	11	178.6
	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	9	0	1	1	0.0
	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	10	2	0	-2	0.0
	үүнээс Хүчиндэх	11	2	0	-2	0.0
хэргийн өнгө	Өмчлөх эрхийн эсрэг /үүнээс/	12	22	54	32	245.5
	Хулгайлах /үүнээс/	13	10	23	13	230.0
	Хувийн өмчийг хулгайлах	14	10	19	9	190.0
	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	15	0	1	1	0.0
	Мал хулгайлах	16	4	6	2	150.0
	Дээрэмдэх	17	0	2	2	0.0
	Залилах	18	5	20	15	400.0
	Хөрөнгө завших	19	1	1	0	100.0
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	20	0	0	0	0.0
	үүнээс Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	21	0	0	0	0.0
	Хүрээлэн байгаа орчны эсрэг	22	0	1	1	0.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	23	0	2	2	0.0
Бусад	24	3	1	-2	33.3	
Хэргийн илрүүлэлт	25	30.2%	20.5%	-9.7	пункт	
Гудамж талбай	26	6	12	6	200.0	
Гэр орон сууцанд үйлдэгдсэн	27	9	25	16	277.8	
Олон нийтийн газарт үйлдэгдсэн	28	4	6	2	150.0	
Согтуугаар үйлдэгдсэн	29	4	5	1	125.0	
Бүлэглэн үйлдсэн	30	7	3	-4	42.9	
Хүүхэд оролцсон	31	4	5	1	125.0	
Эмэгтэй хүн оролцсон	32	8	11	3	137.5	

Эх үүсвэр: Цагдаагийн газар

\* Урьдчилсан гүйцэтгэл

\* Times more

үргэлжлэл

Үзүүлэлт		Өссөн дүнгээр				
		№	2017 IX	2018 IX	Харьцуулалт	
					Зөрүү	Хувь
хохирол	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	33	8	11	3	114.3
	Нийт хохирсон иргэн, байгууллага	34	41	85	44	207.3
	Нас барсан	35	0	3	3	0.0
	Гэмтсэн	36	13	23	10	176.9
	Учирсан хохирол /сая төгрөгөөр/	37	29.6	159.5	129.9	538.9
	Нөхөн төлүүлсэн /сая төгрөгөөр/	38	4.6	16.0	11.4	347.8
	Хохирол нөхөн төлүүлэлтийн хувь	39	15.4	10.1	-5.3	65.6
	Битүүмжилсэн хөрөнгө /сая төгрөгөөр/	40	0	5.0	5	0.0
	Хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл	41	258	379	121	146.9
	Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	42	82	168	86	204.9
өргөдөл мэдээллийн үүнээс	ХБХНээсэн	43	51	97	46	190.2
	ХБХНТатгалзсан	44	25	64	39	256.0
	Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл	45	178	211	33	118.5
	Нийт холбогдогч эмэгтэй	46	14	21	7	150.0
	15 хүртэлх	47	1	7	6	700.0
нас	15 хүртэлх	48	0	0	0	0.0
	16-17 нас	49	2	5	3	250.0
	18-аас дээш	50	11	9	-2	81.8
Холбогдогч Нийгмийн байдал	Малчин	51	1	5	4	500.0
	Төрийн алба хаагч	52	2	1	-1	50.0
	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	53	1	2	1	200.0
	Оюутан сурагч	54	0	2	2	0.0
